## Төслийн онцлох үйл ажиллагаа

① Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг (шимтгэл ногдуулалт, орлого бүрдүүлэлт, тэтгэвэр олголт зэрэг) сайжруулах гарын авлага боловсруулах

Нийгмийн даатгалын үйл ажиллагааг сайжруулахын зэрэгцээ, тав тухтай найрсаг үйлчилгээ үзүүлж, сэтгэл ханамжийг дээшлүүлснээр даатгуулагч, тэтгэвэр авагчдын сэтгэлд хүрсэн чадварлаг найрсаг хамт олныг бүрдүүлж, ажлын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.



Үйлчлүүлэгчтэй харилцах, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлийн богино хугацааны Япон мэргэжилтэн багшийн сургалт зохион байгуулах.



Нийгмийн даатгалын хэлтсүүдэд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа явуулах.

## Төсөл хэрэгжүүлэх зорилго

50 жилийн дараа Монгол Улсын нийгэм эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхийг тааварлах аргагүй ч, өнөөг хүртэлх төрөлтийн хувь хэмжээний өөрчлөлтөөс хүн амын хэтийн тооцоог насны бүлгээр нь гаргаж болно.

- Хүн амын дийлэнхийг эзлэх залуучуудын орон болох Монгол Улс 50, 100 жилийн дараа Япон оронтой адилхан хэмжээний өндөр насжилттай болно болно.
- Хэтийн энэхүү нөхцөл байдалд бэлдэхийн тулд Монгол орон одооноос тэтгэврийн тогтолцоог зөв, тогтвортой хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг дэс дараатай авч хэрэгжүүлэх шаардлагатай.




Эх сурвалж : НҮБ-ын хүн амын хэлтэс（Department of economics and social affairs）「Revision of World Population Prospects」





Төслийн албан ёсны фэйсбүк хаяг
(Япон, Монгол хэл дээр мэдээлэл хүргэдэг)
https://www.facebook.com/JICASocialInsuranceProject/

Жайка төслийн вэб хуудас (сар болгон гаргадаг нийтлэлийг энэхүү вэб хуудаснаас уншиж, танилцах боломжтой)
http://www.jica.go.jp/project/mongolia/014/index.html

Хаяг : Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг Хуульчдын гудамж 13/1 Нийгмийн даатгалын ерөнхий газар 6 давхар 602 тоот

Утас (Факс) : (+976)-11-325125


# Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл (Шинрай)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

SINRAI



## “Шинрай” төсөл гэдэг нь?

Монгол Улс дахь Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалын хамралт, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэлт болон тэтгэвэр олголтын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж буй техник хамтын ажиллагааны төсөл юм.

Хэрэгжих хугацаа : 2016 он 5 сараас 2020 он 5 сар (4-н жил)

Төсөл хамтран хэрэгжүүлэгч : Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Нийгмийн даатгалын ерөнхий газар

## Төслийн зорилтот үр дүн

Зорилго : Нийгмийн даатгалын ерөнхий газрын шимтгэл ногдуулалт, орлого бүрдүүлэлт, тэтгэвэр олголтын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх



① Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг (шимтгэл ногдуулалт, орлого бүрдүүлэлт, тэтгэвэр олголт зэрэг) сайжруулах гарын авлага боловсруулах

② Нийгмийн даатгалын хэлтсүүдэд сургалтын тогтолцоог бүрдүүлэх

③ Нийгмийн даатгалын тогтолцооны талаар ард иргэдэд таниулан сурталчлах болон мэдээллийг түргэн шуурхай хүргэх чадварыг дээшлүүлэх



## Төслийн онцлох үйл ажиллагаа

### ② Нийгмийн даатгалын хэлтсүүдэд сургалтын тогтолцоог бүрдүүлэх

Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, оновчтой хэрэгжүүлэхийн тулд хэлтсийн ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтын системийг сайжруулснаар даатгуулагч болон тэтгэвэр авагчдын хүсэл сонирхолд нийцсэн үйлчилгээ бүхий хэлтсийг бий болгоно.





◉ Сургалт хөгжүүлэх удирдамж боловсруулах, сургагч багш бэлдэх богино хугацааны мэргэжилтэн багшийн сургалт (сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын хөтөлбөр зэргийг боловсруулахтай холбогдуулан сургалт зохион байгуулах, ажилтан мэргэжилтнүүдийг дадлагажуулах сургалт) зохион байгуулна.

## Төслийн онцлох үйл ажиллагаа

### ③ Нийгмийн даатгалын тогтолцооны талаар ард иргэдэд таниулан сурталчлах болон мэдээллийг түргэн шуурхай хүргэх чадварыг дээшлүүлэх

Нийгмийн даатгалын системийн найдвартай тогтвортой байдлыг хангах, мэдээллийг ил тод хүргэснээр даатгалд итгэх итгэлийг дээшлүүлж, даатгалын хамрагдалтын хувь хэмжээг нэмэгдүүлэхээр зорьж ажиллах.



◉ Актуар тооцооны сургалт
(Төрийн албан хаагч, мэргэжилтнүүдэд даатгалын системийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тооцож боловсруулах арга болон удаан хугацаагаар тооцож, бодлого боловсруулж хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлэх зорилготой сургалт)

◉ Японы нийгмийн хамгаалал, хүн ам зүйн судалгааны институт дээр урт хугацааны судалгаа
(Монголын хүн амын хэтийн тооцоолол, бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа)

◉ Нийгмийн даатгалд хамрагдах ач холбогдол, Монгол орны хүн амын бүтцийн хэтийн өөрчлөлтөд нийцсэн даатгалын тогтолцооны тогтвортой найдвартай байдлыг хангах шаардлага болон засгийн газар, ард иргэдийн даатгалын талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
(даатгалын ач холбогдлын талаар байгууллага хамт олон болон оюутан сурагчдад лекц, семинар зохион байгуулах)

